



*The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia*

Хэвлэлийн мэдээ

26.08.2019

Холбоо барих

+976 9511 7771

## **Тав дахь удаагийн “Америкийн Өдрүүд 2019” үзэсгэлэн худалдаанд 60 гаруй байгууллага оролцлоо**

УЛААНБААТАР - Монгол дахь Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол) болон Монгол дахь АНУ-ын Элчин сайдын яам (ЭСЯ) хамтран зохион байгуулдаг “Америкийн өдрүүд” үзэсгэлэн худалдаа тав дахь жилдээ Мишээл Экспод амжилттай зохион байгуулагдаж 60 гаруй байгууллага оролцож Америкийн 100 гаруй брэндийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцууллаа.

Энэхүү хоёр өдрийн үзэсгэлэн худалдаа нь АНУ-ын бараа бүтээгдэхүүнийг олон нийтэд нэг цэгээс танилцуулах, Монгол улсад дэлхийн чанар, стандартыг нэвтрүүлэн ажиллаж буй компаниудын үйл ажиллагааг дэмжих, хэрэглэгчдэд ойртуулах зорилготойгоор зохион байгуулагддаг ба үзэсгэлэнгийн хөтөлбөрт оролцогч байгууллагын танилцуулга, хөгжөөнт арга хэмжээнүүдээс гадна АНУ-ын Элчин Сайдын яамны зүгээс визний тухай болон Америкт суралцах боломжуудын тухай илтгэлүүд зэрэг олон сонирхолтой үйл ажиллагаанууд багтсан юм.

Үзэсгэлэн худалдааны нээлтийн арга хэмжээ 2019 оны 8-р сарын 24-нд болсон ба нээлтийн ёслолын арга хэмжээнд Монгол Улсын Гадаад харилцааны сайд Д. Цогтбаатар, АНУ-ын Элчин сайд Майкл Клечески болон АмЧам Монгол ТУЗ-ийн дэд дарга Гари Биондо нар оролцлоо.

АмЧамын ТУЗ-ийн дэд дарга Гари Биондо арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Манай гишүүд дэлхийн стандартын туршилага болон мэдлэгийг Монголд нутагшуулахын зэрэгцээ инновацид түшиглэн бизнесээ хөгжүүлэн сайжруулж ажилладаг юм. Тиймээс бид Америкийн бизнесүүд Монголд ямар хувь нэмэр оруулж байгааг онцолж сурталчилхаар энэхүү үзэсгэлэнг зохион байгуулдаг билээ” гэв.

АНУ-ын Элчин Сайд Майкл Клечески үг хэлэхдээ, “АмЧамтай хамтран зохион байгуулж буй энэ үзэсгэлэн худалдаагаар Америк бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд найдвартай, сайн чанартай гэдгийг та бүхэн харах болно. Бид АмЧамын хамт олонтой хамтран ажиллахдаа их баяртай байдаг. Энэхүү үзэсгэлэн худалдаа нь өнгөрсөн сарын сүүлчээр Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын АНУ-д хийсэн айлчлалын дараа зохион байгуулагдаж буйгаараа онцлог арга хэмжээ болж байна” гэв.

Монгол Улсын Гадаад харилцааны сайд Д. Цогтбаатар хэлсэн үгэндээ Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын АНУ-д хийсэн айлчлалыг онцлон тэмдэглээд "Айлчлалын үеэр хоёр улсын харилцааг шат ажиулж, байж болох хамгийн өндөр түвшинд хүргэсэн юм. Мэдээж энэ харилцааны маш том бүрэлдэхүүн хэсэг нь эдийн засгийн харилцаа байх ёстой. Худалдааны эргэлт энэ жил өнгөрсөн жилтэй харьцуулахад бараг 40 хувиар өссөн байна. Гэхдээ 2012 онд байсан түвшиндээ хүрээгүй байгаа учраас хийх ажил бидний хувьд маш их байгаа. АмЧам-аас зохион байгуулж буй энэ экспод 70 орчим компани бараа бүтээгдэхүүнээ сурталчлаад зогсохгүй шинэ түншүүдтэй болж байгаагаараа ач холбогдолтой юм." хэмээв.

Тус үзэсгэлэнгийн арга хэмжээг АмЧам Монголын гишүүн Оюу Толгой ХХК, Худалдаа хөгжлийн банк, Орифлэйм Монгол ивээн тэтгэж, Блумберг Монгол ТВ, Форбес Монгол болон MNB World хэвлэл мэдээллийн дэмжигчээр хамтран ажилласан юм.

### **АмЧам Монголын тухай**

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимиын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхimuудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхimuудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.

